

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР
“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ
БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2025 оны 09 дүгээр сарын 28-ны байдлаар/

2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшнийг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 6 зорилтын 19 арга хэмжээ, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

АҮЭБЯ-ны хэрэгжүүлэх 6 зорилтын 19 арга хэмжээний биелэлт 2025 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар **60.5** %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- Зорилт 4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно зорилтын биелэлт **29.0** хувьтай.
- Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно зорилтын биелэлт **54.2** хувьтай.
- Зорилт 4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө зорилтын биелэлт **75.0** хувьтай.
- Зорилт 5.3. Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх зорилтын биелэлт **95.0** хувьтай.
- Зорилт 5.6. Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах зорилтын биелэлт **100.0** хувьтай.

- Зорилт 9.5. Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах зорилтын биелэлт 30.0 хувьтай дүгнэгдлээ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт

/2025 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/

Зорилго	Зорилтын тоо	Хэрэгжилтийн хувь /өссөн/ арга хэмжээний тоо				Хэрэгжилт /2025/	Хэрэгжилт /өссөн/
		85 дээш	60-84	30-59	29 хүртэл		
Зорилт 4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно	1	-	-	-	1	29	29
Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно	12	1	6	5	-	65	54.2
Зорилт 4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө	2	1	-	1	-	70	75
5.3. Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.	2	2	-	-	-	95	95
5.6. Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.	1	1	-	-	-	100	100
9.5. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.	1	-	-	1	-	50	30
Дүн	19	5	6	7	1	67.2	60.5

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

- “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр зорилтот түвшний 85-с дээш хувь буюу “үр дүнтэй” 5, зорилтот түвшний 60-84 хувь бол “үр дүн хүлээгдэж байгаа” 6, хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй” 7, хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь буюу “үр дүн гараагүй” 1 шалгуур үзүүлэлт байна.
- Бодлогын баримт бичигт аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 4 зорилтын 14 зорилт, арга хэмжээ байснаас 2025 онд хяналтаас 4.6.1, 4.6.11 дүгээр арга хэмжээг хасаж, үндсэн болон хамтран хэрэгжүүлэх шинээр 12 арга хэмжээ системд нэмэгдэж орсон бөгөөд үүнээс тус яаманд хамаарахгүй 7 арга хэмжээ байгааг тайлбар хэсэгт оруулсан.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд бусад хөгжлийн бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтээр түвшнийг нарийн тодорхойлох, хэрэгжилттэй уялдуулах,
2. Тодорхой зорилт, арга хэмжээний хүрээнд дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн, зарцуулсан хөрөнгийн талаар биелэлтийг бүрэн, тодорхой, оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах,
3. Хэрэгжилтийг авч хэрэгжүүлсэн ажлуудыг бус гарсан үр дүн талаас тайлагнах, нотлох баримтын бүрдүүлбэрийг хангах,
4. Хэрэгжилт хангалтгүй, үр дүн гараагүй зорилт, арга хэмжээг эрчимжүүлж, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах талаар асуудал хариуцсан нэгжүүдэд зөвлөмж болгох,
5. Бодлого, төлөвлөлтийн алдааг залруулахаар баримт бичигт өөрчлөлт оруулах санал гаргах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР
“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ
ТҮВШИНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2025 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар/

2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшнийг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

АҮЭБЯ-ны хэрэгжүүлэх 3 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2025 оны байдлаар биелэлт **52.7** %-тай дүгнэв. Шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг авч үзвэл:

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ (2025 он)	Үнэлгээ (өссөн)
1.	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь		27
2.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь		0
3.	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь		14.4
	Биелэлт		13.8

2025 оны байдлаар үр дүн гараагүй 1 /0-29%/ арга хэмжээ байна. Үүнд:

- Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээгээр 2025 оны байдлаар хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу "үр дүнтэй" 1, хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй" 1, хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь буюу "үр дүн гараагүй" 1 шалгуур үзүүлэлт байна.
2. "Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро-5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь" шалгуур үзүүлэлтийн 2025 онд 17 хувьтай байгаа ба Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжиж буй дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэр 2028 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа бөгөөд шатахууны өсөн нэмэгдэж буй хэрэглээний 50.0%-ийг хангана гэсэн тооцоололтой байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрэх түвшнийг жил бүрээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтийг хангах,
2. Хэрэгжилт хангалтгүй, үр дүн гараагүй зорилт, арга хэмжээг эрчимжүүлж, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах талаар асуудал хариуцсан нэгжүүдэд зөвлөмж болгох,
3. Бодлого, төлөвлөлтийн алдааг залруулахаар баримт бичигт өөрчлөлт оруулах санал гаргах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР